

## ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО, ХУВЬ НЭМРИЙГ ҮНЭЛЭХ “КРЕДИТ” ТАКСОНОМИ

Нэр томьёо	Тодорхойлолт
Онолын үндэс, санаа	Санаа; онолын санаа, судалгааны зорилго, зорилтуудын томьёолол, боловсруулалтын санаа гаргах
Арга зүй	Судалгааны арга зүй, дизайн; загвар боловсруулах
Софтвейр	Програм, софтвейр боловсруулалт; компьютерийн програм боловсруулалт; компьютерийн код, түүнийг дэмжих алгоритмын хэрэгжүүлэлт; кодын бүрэлдэхүүн хэсгүүдийн туршилтыг боловсруулах
Хүчин төгөлдөр байдал	Судалгаа/туршилтын үр дүн бүхэлдээ эсвэл хэсэгчлэн давтагдах байдлын баталгаа гаргах
Дүн шинжилгээ хийх бэлтгэл	Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, нэгтгэхэд хэрэглэх статистик, математик, тооцоолол болон бусад албан ёсны арга техникүүдийн хэрэглээг боловсруулах, мэдээллийг түүнд түн шинжилгээ хийх програмд оруулах, мэдээллийг цэвэрлэх, дүн шинжилгээ хийхэд бэлтгэх
Мэдээлэл цуглуулалт	Мэдээлэл цуглуулах, нэн ялангуяа туршилт хийх эсвэл мэдээлэл/баримт цуглуулах
Нөөц	Судалгааны материал, урвалж, өвчтөн, лабораторийн бодис, дээж, амьтан, арга хэрэгсэл, тооцоолох болон дүн шинжилгээ хийхэд хэрэглэх бусад нөөцийг хариуцах
Бичилт (эхний хувилбар)	Хэвлүүлэх ажил, түүний эхний хувилбарыг бэлтгэх, боловсруулах, танилцуулах (орчуулах ажил үүнд багтана)
Бичилт (засвар)	Хэвлүүлэх судалгааны ажлын эхний хувилбарыг хянах, засварлах, хэвлүүлэхийн өмнөх болон дараагийн шатны засвар хийх
Мэргэжлийн удирдлага	Судалгааг төлөвлөх, гүйцэтгэх үйл явцыг хянах, удирдлагаар хангах, судалгааг хийх үндсэн багийн гишүүдийг менторлох
Төслийн зохицуулалт	Судалгааг төлөвлөх, гүйцэтгэх менежмент, зохион байгуулалтын үүрэг хариуцлага
Санхүүжилт	Судалгааны төслөөс эхлэн хэвлүүлэх хүртэлх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг босгох, бүрдүүлэх

Бранд нар (2015), Лейрнед Пабблишинг 28(2)-аас тохируулан өөрчилж хэрэглэв

Эх сурвалж: <https://www.cell.com/pb/assets/raw/shared/guidelines/CRediT-taxonomy.pdf>

Энэхүү таксономийн дагуу зохиогчдын оролцоог дараах байдлаар бичнэ:

**Онолын үндэс, санаа:** Д.Д., Б.Б; **Арга зүй:** Д.Д., Б.Б; **Мэдээлэл цуглуулалт:** Д.Д., Б.Н; **Бичилт (эхний хувилбар):** Д.Д., Б.Б., Б.Н; **Бичилт (засвар):** Д.Д., Б.Б., Б.Н; **Санхүүжилт:** Д.Д; **Нөөц:** Б.Н; **Мэргэжлийн удирдлага:** Д.Д.